

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн
хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 сарын 06-ны өдрийн 1/20 дугаар удирдамжийн дагуу Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрүүл мэндийн тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун би 2017 оны 11 сарын 06-ны өдрөөс хуанлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, хүнсний бүтээгдэхүүн, эм, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Баян-Агт сумын 6-р багт байрлах 9012923 регистрийн дугаартай Эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй хүргэж үйлчлэх зорилготой.

Сумын хүн ам 2016 онд 909 өрхийн 3119 байгаа ба тус төв нь 3 - р зэрэглэлд (3001-4500 хүн амтай бол III-р зэрэглэл) хамаардаг.

Эрүүл мэндийн төвийн даргын 06 сарын 08-ны өдрийн А/10 “Орон тоо батлах тухай” тушаалаар их эмч 3 /1 их эмч даргын албан тушаалыг хавсрах/, эх баригч бага эмч 1, дүн бүртгэгч бага эмч 1, сургалтын арга зүйч бага эмч 1, багийн бага эмч 5, ахлах сувилагч 1, амбулаторийн сувилагч 1, ээлжийн сувилагч 4, үйлчлэгч 3, ариутгагч автоклавчин, лаборант, тогооч, жолооч, нярав тус бүр 1, галч 4 нийт үндсэн 25, гэрээт ажилтан 4 орон тоотой ажиллахаар баталсанаас төвийн дарга, их эмч 1, их эмч 2, эх баригч бага эмч 1, сургалтын арга зүйч бага эмч 1, дүн бүртгэгч бага эмч 1, багийн бага эмч 5, ахлах сувилагч 1, ээлжийн сувилагч 4,

үйлчлэгч 3, лаборант, тогооч, жолооч, нярав тус бүр 1, гэрээт ажилтан /галч/ 4 нийт үндсэн 23, гэрээт ажилтан 4 орон тоотойгоор ажилласан байна.

Тус төвийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 01 сарын 01-ээс 09 сарын 12-ны өдрийг хүртэл Л.Амарсанаа, 09 сарын 26-ны өдрөөс 10 сарын 31-ний өдрийг хүртэл Ж.Алтан-Од, 11 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг дуустал М.Бат-Эрдэнэ, 2-р гарын үсгийг 01 сарын 01-ээс 02 сарын 29-ний өдрийг хүртэл Г.Оюунтуяа, 03 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг дуустал Б.Отгонцэцэг нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040120001 тоот, нэмэлт санхүүжилтийн 040120401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох "CTS" программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан тул аймгийн Аудитын газраас дүгнэлт өгөгдөөгүй байна.

Шалгалтанд хамрагдсан оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд бусад байгууллагаас шалгалт хийгдээгүй байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Баян-Агт сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны касс харилцах, хүнс, бараа материалын баримт, эргэлтийн эмийн сангийн болон тендерийн эмийн баримт, цалингийн карт, байгууллагын даргын тушаал, санхүүгийн тайлан, сумын эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдын 2013 оны 03 сарын 20-ны өдрийн хурлаар баталсан хөдөлмөрийн дотоод журам, цагийн бүртгэл, хүнс, бараа материалын хөдөлгөөн, үлдэгдлийн бүртгэл зэрэг баримт материалуудад тулгуурлан төвийн дарга, их эмч асан Л.Амарсанаа, нягтлан бодогч Б.Отгонцэцэг, дүн бүртгэгч бага эмч Д.Рэгзэдмаа, сувилагч Т.Чанцал, нярав Д.Батсүрэн нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

Тайлант онд төсвөөс 312850.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, тодотголоор 2000.0 мянган төгрөгөөр нэмж, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид 6437.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар Эрүүл мэндийн газраас улаан бурхан-улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтын ажлын шатахууны зардалд 321.0 мянган төгрөг бүгд 321612.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлыг 314850.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 234090.5 мянган төгрөг, тогтмол зардалд 18311.1 мянган төгрөг, нормативт зардалд 23766.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 14914.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2472.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 814.8 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 1996.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил

үйлчилгээний бусад зардалд 543.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ буюу галч нарын цалинд 11640.6 мянган төгрөг, магадлан итгэмжлэлийн үйлчилгээний төлбөрт 450.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 5318.0 мянган төгрөг нийт 314317.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 536.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Тус сумын Эрүүл мэндийн төвийн магадлан имтгэмжлэлийн хугацаа 2016 оны 03 сард дууссан учраас хугацааг сунгуулахаар магадлан имтгэмжлэлийн үйлчилгээний төлбөрт 450.0 мянган төгрөг төлсөн байна.

Нэмэлт орлогын талаар: Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар “Улаанбурхан-улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалт”-ын ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна. Ажлын хэсэг 05 сарын 10-аас 25-ны өдрүүдэд уг ажлыг зохион байгуулсан ба сумын төвд байнгын 1 цэг, багийн төвд 5 түр цэг гарган сумдын 18-30 насны 673 иргэдийг тарилгад болон сургалт сурталчилгаанд хамруулж, нийт 907 км явж 150 л шатахуун зарцуулсан байна.

2016 онд амбулаторийн үзлэгээр нийт 5808 хүн үзэж 376 хүнийг хэвтэн эмчлүүлж, 2466 ор хоног ашигласан ба орны эргэлт 6. Нийт 458 дуудлага ирж үүнээс талдаа 70 км-ээс дээш зайд явсан дуудлага 50 байна. Жирэмсэний хяналтанд шинээр 58 эхийг хамруулж, үүнээс 11 эхийг төрүүлсэн байна. Нийт үзлэгийн 43.9 хувийг их эмчийн, 22.4 хувийг багийн бага эмчийн, 13.6 хувийг эх баригч бага эмчийн, 20.1 хувийг бага эмчийн үзлэг тус тус эзэлж байна.

6.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд нийт 109 мэдээлэл оруулахаас 108-г хугацаанд нь мэдээлж, 3 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар:

Дарга Л.Амарсанаад сумын Засаг даргын захирамжаар 1-р улиралд 742.2 мянган төгрөг, 2-р улиралд 0-1, 1-5 насны хүүхдийн эндэгдэл гаргалгүй ажилласан гэж нэг сарын үндсэн цалингаар буюу 742.2 мянган төгрөгийн урамшуулсан байна.

Монгол улсын Засгийн газрын 150 дугаар тогтоол, Эрүүл мэндийн тухай хуулийн 29.4, Хөдөлмөрийн дотоод журмын 5.2 дахь заалтуудыг үндэслэж сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар 1-р улиралд 18 албан хаагчдад 2991.9 мянган төгрөг, 2-р улиралд 18 албан хаагчдад 3426.4 мянган төгрөг, 3-р улиралд 19 албан хаагчдад 4299.0 мянган төгрөг, 4-р улиралд 17 албан хаагчдад 3995.7 мянган төгрөг, бүгд 14813.0 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалт цалин олгожээ.

Нягтлан бодогч Б.Отгонцэцэгт тус төвийн даргын 09 сарын 05-ны Б/22 дугаар тушаалаар 2-р улирлын урамшуулал 100.0 мянган төгрөг, 12 сарын 02-ны Б/34 дүгээр тушаалаар 4-р улирлын урамшуулал 100.0 мянган төгрөг, тус төвийн даргын 12 сарын 22-ны Б/37 дугаар тушаалаар 2016 оны жилийн ажлын урамшуулал гэж 60.0 мянган төгрөг тус тус олгосон байна.

Дүн бүртгээгч бага эмч Д.Рэгээдмааг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2016 оны 08 сарын 18-ны Б/21 дүгээр тушаалаар статистик тайлан мэдээ ирүүлсэн байдал, явцын үнэлгээний дүнгээр “А” үнэлэгдсэн гэж 2 сарын хугацаатай үндсэн цалингийн 20 хувиар буюу 223.5 мянган төгрөгөөр шагнажээ.

Сумын Засаг даргын захирамжаар дарга Л.Амарсанаад хүүхдийн эмчийн албан тушаалыг хавсруулж, үндсэн цалингийн 40 хувиар тооцож 2012.2 мянган төгрөг, их эмч Ж.Алтан-Одод 06, 09, 10 сард эрүүл мэндийн төвийн даргын үүрэгт ажлыг хавсруулж, үндсэн цалингийн 40 хувиар тооцож нийт 497.6 мянган төгрөг, их эмч М.Бат-Эрдэнийг 11 сарын 01-ээс төвийн даргын үүрэгт ажлыг хавсруулж үндсэн цалингийн 30 хувиар тооцон 335.1 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл цалин олгосон байна.

6.3 Өглөг, авлагын талаар: Авлагын хувьд оны эхэнд хувь хүнээс авах 132.5 мянган төгрөгийн авлагатай байгаа бол өглөгийн хувьд оны эхэнд түлш халаалтын 1.0 мянган төгрөг, оны эцэст Монос фарм трейд ХХК-д эмийн 1655.8 мянган төгрөгийн өглөгтэй байна.

6.4. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2016 оны эхний үлдэгдэл 375033.3 мянган төгрөгийн хөрөнгө дээр 480.0 мянган төгрөгөөр багаж ариутгагч машин, 1450.0 мянган төгрөгөөр проектор, 220.0 мянган төгрөгөөр эмийн хөргөгч, 380.0 мянган төгрөгөөр цэвэрлэгээний тэргэнцэр, 150.0 мянган төгрөгөөр чихний дуран 2680.0 мянган төгрөгөөр худалдан авч, Эрүүл мэндийн газраас 7500.0 мянган төгрөгийн нярайн энкобатор, 2136.7 мянган төгрөгийн үнэтэй суурин компьютер, 1309.5 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 6 ш өвчтөний функциональ ор, 90.0 мянган төгрөгөөр рутер бүгд 17583.8 мянган төгрөг, Дэлхийн олон улсын байгууллагаас 2534.0 мянган төгрөгийн үнэтэй нярайн фото шарлагын аппарат үнэ төлбөргүй өгсөн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 14696.8 мянган төгрөгийн үнэтэй морогийн байр барьж нийт 37494.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, оны эцэст 412527.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

6.5. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

Тайлант оны эхний үлдэгдэл 35880.1 мянган төгрөг дээр төсвийн хөрөнгөөр 7239.1 мянган төгрөгөөр аж ахуйн, 1433.3 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 6300.0 мянган төгрөгөөр 300 м³ түлшний мод, 5277.2 мянган төгрөгөөр 65 тн нүүрс, 12023.6 мянган төгрөгөөр шатах тослох, 5794.3 мянган төгрөгөөр хүнс, 14953.7 мянган төгрөгөөр эм боох материал, 2970.7 мянган төгрөгөөр тусгай зориулалтын материал, 175.0 мянган төгрөгөөр сэлбэг хэрэгсэл худалдан авч, Эрүүл мэндийн газраас 160.0 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 2 ш автомашины дугуй, 50.0 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 4 ш амартизатор үнэ төлбөргүй ирсэн, туслах аж ахуйн нас дэвшилтээр 57 толгой, шинэ төл 22 толгой мал нэмэгдэж, хэвтэн эмчлүүлэгчдийн хоолонд 37 толгой хонь нядалж 465.5 кг буюу 1629.3 мянган төгрөгийн мах, 53031.6 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, устгалын актаар 1820.0 мянган төгрөгийн 52 толгой мал хорогдож, оны эцэст 38785.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эхэнд 5040.0 мянган төгрөгийн 240 м³ түлшний мод, 1906.2 мянган төгрөгийн 25 тн нүүрсний үлдэгдэл дээр сумын иргэн М.Цогтгэрэл,

Н.Мягмарсүрэн нартай түлшний мод, Илчит металл ХХК-тай нүүрс нийлүүлэхээр гэрээ байгуулж, 2 иргэнээс 6300.0 мянган төгрөгөөр 300 м³ мод бэлтгүүлэн актаар хүлээн авч, галлагаанд 7602.0 мянган төгрөгийн 362 м³ мод зарцуулж, оны эцэст 3738.0 мянган төгрөгийн 178 м³ модны үлдэгдэлтэй, Илчит металл ХХК-иас 5277.2 мянган төгрөгөөр 65 тн нүүрс худалдан авч, галлагаанд 5511.7 мянган төгрөгийн 70 тн нүүрс зарцуулж, оны эцэст 1671.7 мянган төгрөгийн 20 тн нүүрсний үлдэгдэлтэй тайлан баланс гаргасан байна.

Туслах аж ахуйн тооцоо: Оны эхэнд 3449.0 мянган төгрөгийн үнэ бүхий 96 толгой хонь, 12 толгой ямаа үлдэгдэл дээр шинэ төл 2 ишиг, 20 хурга, нас дэвшилтээр нийт 79 толгой мал нэмэгдэж, эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар 37 толгой хонь хэвтэн эмчлүүлэгчдийн хоолонд, нас дэвшилтээр 57 толгой мал, устгалын актаар 41 толгой хонь, 11 толгой ямаа хорогдож, оны эцэст 1070.0 мянган төгрөгийн үнэ бүхий 38 толгой хонь, 3 толгой ямаа үлдсэн байна. /тооцоо бодсон нягтлан бодогч Б.Отгонцэцэгийн тайланг үндэслэв./

Эм, эмнэлгийн хэрэгсэл Моносфарм трейд ХХК-иас 10767.3 мянган төгрөгийн, Мөнхийн тун ХХК-иас 766.0 мянган төгрөг, Булган эм хангамж ХХК-иас 1951.3 мянган төгрөг, Нуган 640.0 мянган төгрөг, Айко 163.5 мянган төгрөг, Нахиа шинэс 41.5 мянган төгрөг, СОБЦ 200.0 мянган төгрөг, Цэгээн тун 1957.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж худалдан авч, Баян-Агт хөгжил санд оношлуурын үнийн дутуу 145.7 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

1. Үндэсний бизнес хөгжлийн нэгдэл ТББ-аас тус төвийн хамт олны нөр их хөдөлмөр бүтээлийг нь үнэлж Их хааны хүндэт “ХИЧЭЭНГҮЙ ЗҮТГЭЛ МӨНГӨН ГЭРЭГЭ” цом өргөмжлөл хүртээсэн байна.

2. Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан.

3. Түргэн тусламжийн дуудлагаар явсан илүү цагийн түүвэрт өвчний түүхийн дугаарыг тавьсан байгаа нь шалгалт хийхэд хялбар байв.

НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид 6437.8 мянган төгрөг орж ирсэн байхад тайлан балансад 7447.2 мянган төгрөгөөр тусган 1009.5 мянган төгрөгийн тэтгэмж давхар бүртгэсэн байна.

2. Тус төвийн ажиллагсдын улирлын ажлын үр дүнг улирал бүр буюу 4 удаа үнэлж дүгнэн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон атал дээр нь нэмж сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2016 оны 12 сарын 22-ны Б/37 дугаар тушаалаар *Хөдөлмөрийн тухай хуулийн 50.1, Хөдөлмөрийн дотоод журмын 5.2 дахь заалтуудыг* үндэслэж 26 хүнд тус бүр 60.0 мянган төгрөг, 4 хүнд тус бүр 40.0 мянган төгрөг, 1 хүнд 39.4 мянган төгрөг бүгд 1759.4 мянган төгрөгийн урамшуулалт цалинг давхардуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, 13.7 дахь заалтуудыг зөрчсөн.

3. Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан огт гаргаагүй, анхан шатны баримтуудыг дугаарлаагүй, хоолны өдөрлөгт жинхэнэ олгосон тоо хэмжээг тавьдаггүй, шаардах

хуудсыг буруу бичдэг, улирлын ажлын үр дүнг үнэлсэн үнэлгээний хуудсыг үдэж архивлаагүй.

4. Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг харгалзан “А”, “В” гэж бүх шалгуурын биелэлтийг хувиар үнэлж байгаа ч мөнгөн урамшлыг олгохдоо 50, 55, 60 гэх мэт хувиар, мөн 25000, 30000, 100000 гэх мэт мөнгөн дүнгээр олгохоор шийдвэрлэж байгаа нь Засгийн газрын 150 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын 2.5-д /Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараахь хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшлыг тооцно: 90-100 хувь буюу “А” үнэлгээ авсан бол 11-15 хувь, 71-89 хувь буюу “В” үнэлгээ авсан бол 10 хувь хүртэл/ заасныг зөрчсөн.

5. Цалингийн гарт олгох хүснэгт санхүүгийн баримтанд байхгүй.

6. Бараа материалыг орлогодохдоо тайлангийн нэр төрлөөр бус цаад газрын зарлагын баримтыг “Орлогын баримт” анхан шатны баримтан дээр хуулбарлаж бичин буруу хөтөлдөг, агуулахын бүртгэл хөтлөөгүй, бичгийн цаасыг боодлоор орлогодож, боодлоор зарлагаддаг, аж ахуйн материалын тайланд цэвэрлэгээ, урсгал засвар, сэлбэг хэрэгслийн материалыг тусгаж зарцуулсан, шатахуун түгээх станцаас шатахууны оронд бэлэн мөнгө авдаг,

7. Малчинтай гэрээ байгуулаагүй, хэвтэн эмчлүүлэгчдийн хоолонд зарцуулахаар нядалсан 37 хонины 465.5 кг махыг орлогын баримт үйлдэлгүй тайланд тусгасан, 37 хонины гэдэс орлогод аваагүй, зөвшөөрлийн хуудсыг санхүүгийн баримтанд хавсаргаагүй, хонь, ямааны ноос, ноолуур, арьс ширний орлогын тооцоог хийдэггүй, нядалгааны актад хорогдсон малын тоог засвартай үйлдсэн.

8. Сумын эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдын 2013 оны 03 сарын 20–ны өдрийн хурлаар баталсан хөдөлмөрийн дотоод журмын зарим заалтад нэмэлт өөрчлөлтийг гараар бичиж оруулсан, тушаал, хамт олны хурлаар баталгаажуулаагүй.

9. Тайлант онд хувь хүнээс авах авлага 132.5 мянган төгрөг байгаа ба эзэн нь тодорхойгүй байна.

10. Сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдын цалинг үндсэн цалингаас бууруулалгүй, олговол зохих цалингаас хасч тооцсон, хавсран ажилласны нэмэгдлийг ажиллаж буй албан тушаалын цалингаас бодож цалин илүү олгосон, илүү цагийн хөлсийг тухайн сард ногдох цагаар бус тогтмол 176 цагт ногдуулж, мөн ээлжийн графикаар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтанд нийтээр амрах баярын өдөр болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан илүү цагийн хөлсийг 2 дахин нэмэгдүүлж бодсон.

11. Ажлын цаг ашиглалтын бүртгэлд сургалтанд хамрагдсан албан хаагчдыг ажилд ирсэнээр бүртгэсэн.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 1 албан шаардлага үйлдэж, улсын байцаагчийн 5 актаар нийт 30916.8 мянган төгрөгийн төлбөр тогтоогдсоноос 3950.8 мянган төгрөгийг нөхөн олгохоор, 21325.2 мянган төгрөгийг сумын эрүүл

мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд, 5640.8 мянган төгрөгийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоолоо.

Шалгалтын хугацаанд 4 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Засгийн газрын 2001 оны 90, 2010 оны 108, 1995 оны 96 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 13.7, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан зааврыг мөрдөж ажиллаагүй, байгууллага дотооддоо бүртгэлээр тавих хяналтыг хийгээгүйгээс зөрчил дутагдлууд илэрлээ гэж дүгнэлээ.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан зааврыг хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Сэлбэг шатахууны зардлын гүйцэтгэлд хяналт тавих хяналтыг сайжруулж, шатахууны тооцоог бодож хэвших, автомашины шатахууны 100 км-т зарцуулах нормыг тооцохдоо Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм”, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар”-ыг мөрдөж ажиллах

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

